# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 21 өдөр Дугаар А/354 Улаанбаатар хот

Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, 9.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалахад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн их цэвэрлэгээний арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд дараах чиглэлээр зохион байгуулсугай:

1.1.Цэвэрлэгээний ажлыг ерөнхий зохион байгуулалт, нэгдсэн удирдлагаар хангах, нийслэлийн харьяа газар, агентлагуудын цэвэрлэгээ хийх газрын хуваарь, цэвэрлэгээний ажлын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтийг зохион байгуулж, явц үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэж Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Г.Батзоригт;

1.2.Орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн талбай, өөрийн эзэмшлийн хашаан доторх хог хаягдал, байгууллагын хана, фасад, цонх, хаяг, хаягийн байгууламж, сандал, хогийн сав, үүдийг угаах, засварлах, гадна талбайгаа усалж чийгшүүлэх, цэвэрлэгээний ажилд ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулж, идэвхтэй оролцуулахыг Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн бүх аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодын удирдлагад;

1.3.Цэвэрлэгээний ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, дүүргийн ТҮК, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг цэвэрлэгээний ажлын удирдамжид заасан чиглэлийн дагуу цэвэрлэгээний ажилд уриалан, бүх нийтээр татан оролцуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт.

2.Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээ, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах, хотын соёлыг дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Баярцэцэг)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725021694

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

1725020982

БАТЛАВ.
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ

# БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ УДИРДАМЖ

**Зорилго:** Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг угааж цэвэрлэх, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг засварлаж, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

**Хэзээ:** 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл

**Хамрах хүрээ:** Нийслэлийн 9 дүүрэг

**Зохион байгуулалт:** Их цэвэрлэгээ нь 3 үе шаттай явагдах бөгөөд чиг үүрэг хариуцсан мэргэжлийн байгууллагууд дараах төлөвлөгөөний дагуу төлөвлөгдсөн ажлыг товолсон өдөр гүйцэтгэж ажиллана. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба төлөвлөгөөнд дурдсан нийт ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

| № | Арга хэмжээ | Ажиллах өдөр | | | Хариуцах байгууллагууд | Хяналт тавьж ажиллах хэлтэс, байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| | | 03.22-03.28 | 03.29-04.04 | 04.05-04.12 | | |
| **Хог хаягдлын цэвэрлэгээ, угаалга, халдваргүйтгэлийн чиглэлээр** | | | | | | |
| 1 | Өөрсдийн хариуцсан гудамжны автобусны буудлуудын угаалга цэвэрлэгээ | | | | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ<br>Дүүргийн ТҮК | Дүүргүүдийн хяналтын ТББ-ууд |
| 2 | ЖИСИДЭКО Монголиа ХХК гэрээт автобусны буудлын угаалга цэвэрлэгээ | | | | ЖиСиДэко Монголиа ХХК | УБЗАА-ны Тохижилт хог хаягдлын удирдлагын газар |
| 3 | Авто замын эгнээ тусгаарлах хайс хашлага, ногоон байгууламжийн түүвэр цэвэрлэгээ хийх, тросон хашлагыг угаах | | | | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ<br>Дүүргийн ТҮК<br>Ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ хариуцсан байгууллагууд | УБЗАА-ны Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс |
| 4 | Орон сууцны орц, хаалга, лифтийг угаах, халдваргүйтгэл хийх, гадна орчны цэвэрлэгээг хийх, Хүүхдийн тоглоомын талбайг угааж цэвэрлэх, засаж сэлбэх, өнгө будгийг сэргээх | | | | - Дүүргийн ЗДТГ<br>- МСӨХДЗ ТББ<br>- СӨХ-үүд | - УБЗАА-ны Хотын инженерийн дэд бүтцийн газар<br>- МСӨХДЗ ТББ |
| 5 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон ЕБС, Их дээд сургуулийн орчны 50 метр хүртэлх цэвэрлэгээ | | | | УБЗАА-ны Орчны бохирдол хог, хаягдлын удирлагын хэлтэс | Нийслэлийн боловсролын газар |
| 6 | Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн орчны 50 метрийн угаалга, цэвэрлэгээ | | | | УБЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар | Дүүргийн ЗДТГ, Нийслэлийн эрүүл мэндийн газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Нүхэн болон гүүрэн гарц, Замын тэмдэг тэмдэглэгээг угааж цэвэрлэх, засварлах | | | | Улаанбаатар Зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ | УБЗАА-ны Хотын инженерийн дэд бүтцийн газар |
| 8 | Авто замын нуух, зорчих хэсгийг тусгай зориулалтын шүүртэй машинаар угааж цэвэрлэх | | | | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ<br>Дүүргийн ТҮК | Дүүргийн ЗДТГ |
| 9 | Гудамж талбайд байршуулсан хогийн савнуудыг угааж, эвдэрснийг засварлах | | | | Дүүргийн ТҮК | Дүүргийн хяналтын ТББ-ууд |
| 10 | Богд уулын иргэдийн алхдаг зам дагуух хогийн цэг, туул голын эрэг дагуу тохижилт хийсэн талбай, орон сууц, гэр хорооллын дунд үүссэн үүсмэл хогийн цэгүүдийг ачиж, цэвэрлэх | | | | Хот тохижилтын газар ОНӨААТҮГ<br>Дүүргийн ТҮК | Дүүргийн ЗДТГ<br>Дүүргийн Хяналтын ТББ-ууд |

**Төлөвлөгөөт ажилд хяналт тавих:**

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны газар, хэлтсүүд чиг үүргийн хүрээнд төлөвлөгөөний дагуу өдөр бүр хяналт тавьж ажиллана. Төлөвлөгөөний хэрэгжилтэд Дүүргийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, ТББ-ууд, ТҮК, СӨХ-ын ажилд газар дээр нь хяналт тавьж ажиллана.

**Төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлыг сурталчилах:**

Төлөвлөгөөнд заасан ажлын явц мэдээллийг НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Захиргаа, санхүүгийн удирдлагын газар хамтран албаны цахим хуудсаар өдөр бүр сурталчлах, мөн бусад хэвлэл мэдээллийн сувгуудаар сурталчилж ажиллана. Дүүргийн ЗДТГ нь төлөвлөгөөний дагуу дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа ажлыг тухай бүр сурталчилж, иргэдэд мэдээлэл өгч ажиллана.

**Үр дүнг тайлагнах:**

Энэхүү удирдамж, ажил хариуцсан байгууллага төлөвлөгөөнд тусгагдсан ажил бүрээр тоон мэдээллийг тухайн долоон хоногийн Пүрэв гарагийн 16:00 цагт Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв НӨҮГ-т dispatcher_ub@yahoo.com хаягаар word файлаар илгээх Шуурхай удирдлага, зохицуулалтын төв мэдээллийг нэгтгэн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд ирүүлнэ.

**ОРЧНЫ БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

БАТЛАВ.
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Г.БАТЗОРИГ

### УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ, ХАРЬЯА ГАЗРУУДЫН ЦЭВЭРЛЭХ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ ТАЛБАЙН ХУВААРЬ

**Зохион байгуулагч:** Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
**Хугацаа:** 2025 оны 03 дугаар сарын 28-ны Баасан гаригийн 11:00:12:30 хүртэл 90 минут
**Чиглэл:** Хариуцсан зам талбайн зөвхөн явган хүний замын дэргэдэх түүвэр хог хаягдлыг цэвэрлэнэ. Байгууллага бүр цэвэрлэгээнд шаардлагатай бээлий, хог түүх хэрэгсэл, шуудайтай ирнэ. Цэвэрлэсэн хог хаягдлыг шуудайны амыг баглаж төв зам дагуу тавих.
**Хариуцах байгууллага:** Дүүргийн ЗДТГ

| | | |
|---|---|---|
| 1 | Бизнес, инновацын газар | Олимпийн гудамж, Гадаад хэргийн яамны уулзвараас Замын цагдаагийн уулзвар хүртэл |
| 2 | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар | |
| 3 | Нийслэлийн Архивын газар | Гадаад хэргийн яамы урд уулзвараас Төв номын сангийн хойд уулзвар хүртэл |
| 4 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар | |
| 5 | Нийслэлийн Байгаль орчны газар | |
| 6 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар | |
| 7 | Нийслэлийн Боловсролын газар | 1-р эмнэлгийн хойд талын уулзвараас Япон элчингийн зүүн талын уулзвар хүртэл /Зоригийн гудамж/ |
| 8 | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба | |
| 9 | Нийслэлийн Дотоод Аудитын алба | 1-р эмнэлгээс Сонгдо эмнэлгийн хойгуур Гадаад хэргийн яамны баруун урд уулзвар хүртэл |
| 10 | Нийслэлийн Замын хөгжлийн газар | |
| 11 | Нийслэлийн Мал эмнэлгийн газар | Энхтайвны гүүрнээс Нарантуулын уулзвар хүртэл Нарны зам дагуу хойд талдаа |
| 12 | Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар | |
| 13 | Нийслэлийн Онцгой байдлын газар | |
| 14 | Нийслэлийн Орон сууцны бодлогын газар | Энхтайвны гүүрнээс Нарны гүүр хүртэл Нарны зам дагуу хойд талдаа |
| 15 | Нийслэлийн Соёл, урлагийн газар | |
| 16 | Нийслэлийн Статистикийн газар | |
| 17 | Нийслэлийн Татварын газар | Энхтайвны гүүрний зүүн тохой, Нарны замын хойд талын хэсэг |
| 18 | Нийслэлийн Улсын бүртгэлийн газар | |
| 19 | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар | Энхтайвны гүүрний баруун тохой, Нарны замын хойд талын Моннистой тал |
| 20 | Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар | |
| 21 | Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | Энхтайвны гүүрний баруун болон зүүн талын тохой, Милая кафегаас төрийн далбаатай тойрог хүртэл |
| 22 | Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар | |
| 23 | Нийслэлийн Цагдаагийн удирдах газар | Жуулчны гудамж, Цаг уурын уулзвараас баруун тийшээ Бөмбөгөр захын баруун урд талын гэрлэн дохио хүртэл |
| 24 | Нийслэлийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газар | |
| 25 | Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар | Арслантай гүүрнээс Дамдинсүрэнгийн гудамжны гүүр хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу |
| 26 | Нийслэлийн Өмчийн харилцааны газар | |
| 27 | Нийтийн тээврийн бодлогын газар | Төв бассейнаас Бээжингийн гудамж хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу |
| 28 | Хот байгуулалт, хотын стандартын газар | |
| 29 | Хяналт шалгалтын газар | Нийслэл хүрээ өргөн чөлөө, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс 120 мянгатын тэмээтэй уулзвар хүртэл |
| 30 | "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ | |
| 31 | Бодлогын судалгаа шинжилгээний төв | Дамдинсүрэнгийн гудамжны гүүрнээс Нарны зам хүртэл Сэлбэ голын баруун талын зам дагуу |
| 32 | Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ | |
| 33 | Монголын Хүүхдийн урлан бүтээх төв | Бээжингийн гудамжнаас ХҮДС-ын баруун талаар Энхтайвны өргөн чөлөө хүртэл /Оюутны гудамж/ |
| 34 | Монголын хүүхдийн ордон НӨТБ | |

| | | |
|---|---|---|
| 35 | Нийгмийн хамгааллын тусгай төв | Авто плазаагийн баруун талын уулзвараас урагш Дашчойлон хийд, цаашаа Хөгжим бүжгийн коллежийн зүүн хойд уулзвар хүртэл /Жамбын Батмөнхийн гудамж, Н.Содномын гудамж/ |
| 36 | Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ | |
| 37 | Нийслэлийн Төр захиргааны Авто бааз УТҮГ | Сөүлийн гудамжнаас Энхтайвын өргөн чөлөө хүртэл 45-р сургуулиас Улаанбаатар их дэлгүүр хүртэл /Намнансүрэнгийн гудамж/ |
| 38 | Соёлын төв өргөө | |
| 39 | Улаанбаатар лифт ОНӨТҮГ | Энхтайвны өргөн чөлөөнөөс Сөүлийн гудамж хүртэл УИДэлгүүрийн чанх урд талын гудамж /Цэрэндоржийн гудамж/ |
| 40 | Улаанбаатар театр ОНӨТҮГ | |
| 41 | Улаанбаатар хотын Нийтийн төв номын сан | АТГ-ын зүүн талаас хойшоо Энхтайвны өргөн чөлөө хүртэл зам дагуу /Партизаны гудамж/ |
| 42 | Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ | |
| 43 | Улаанбаатар хотын музей | Сөүлийн гудамжнаас Энхтайвын өргөн чөлөө хүртэл Орос илчингийн баруун талын зам /Чин ван Ханддоржийн гудамж/ |
| 44 | Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор | |
| 45 | Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ | Тэди төвийн уулзвараас Их дэлгүүр хүртэл /Баруун сэлбийн гудамж/ |
| 46 | Асгат ОНӨААТҮГ | |
| 47 | Багачууд хүнс ОНӨААТҮГ | Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэл |
| 48 | Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ | |
| 49 | Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ | Амарын гудамж, Соёлын төв өргөөний арын зам |
| 50 | Дулааны тавдугаар цахилгаан станц ОНӨААТҮГ | |
| 51 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ | Соёлын төв өргөөний 4 талын зам, талбай /Амарын гудамж, Их сургуулийн гудамж/ |
| 52 | Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ | |
| 53 | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ | Энхтайвны өргөн чөлөө, Зүүн 4 замаас Оффицерудын ордон хүртэл |
| 54 | Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ | |
| 55 | Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ | Өлзийт төвийн уулзвараас 32 тойрог хүртэл /Ногоон нуурын гудамж/ |
| 56 | Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ | Хувьсгалчдын гудамж, Бөмбөгөр захын гэрлэн дохионоос Тасганы овооны Петровисын уулзвар |
| 57 | Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ | |
| 58 | Хүнс хангамж төв ОНӨААТҮГ | |
| 59 | Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ | Баруун 4 замаас Бөмбөгөр захын гэрлэн дохио хүртэл |
| 60 | Багануур Үйлдвэрлэл, технологийн парк ХК | |
| 61 | "Эмээлт эко аж үйлдвэрийн парк" ХК | Ажлын байрны эргэн тойронд 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбай |
| 62 | Нийслэлийн Орон сууцны корпораци ХК | Анкарагийн гудамж, Зоос гоёлын уулзвараас СУИС-ийн уулзвар хүртэл |
| 63 | Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК | |
| 64 | Олон улсын худалдаа логистикийн төв ХК | Топ мебель дэлгүүрээс Бөхийн өргөөний уулзвар хүртэл /Токиогийн гудамж/ |
| 65 | Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК | |
| 66 | Таван толгой түлш ХХК | Япон элчингийн баруун уулзвараас зүүн тийшээ Сэлбэ гол хүртэл /Элчингийн гудамж/ |
| 67 | Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК | |
| 68 | Төв цэнгэлдэх хүрээлэн | Хуримын ордны урд талаас Хүүхдийн ордны баруун талын уулзвар хүртал замын /Гэндэнгийн гудамж/ |
| 69 | Улаанбаатар орон сууцжуулалт ХХК | |
| 70 | Улаанбаатар спорт менежмент ХК | Номын сангийн байрнаас урагшаа нарны зам хүртэл |
| 71 | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК | |
| 72 | Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл | Сөүлийн гудамж, Драмын театрын уулзвараас Голомт хотхоны уулзвар хүртэл |
| 73 | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж | |
| 74 | Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төслийн нэгж | Денверийн гудамж, Бээжингийн гудамжны гүүрнээс 100 айлын гүүр хүртэл |
| 75 | Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл | |
| 76 | Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг удирдах нэгж | Тусгаар тогтнолын талбай |
| 77 | Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл | |

ОРЧНЫ БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС